



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/186

Шивээговь сум

Эзэмшил газрыг нэгтгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.1.3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Страто ХХК нь Шивээговь сумын 2 дугаар баг, 21 дүгээр зөрлөгийн баруун урд талд байрлах 22,5 га болон 100 га үйлдвэрлэлийн зориулалттай газруудыг нэгтгэх хүсэлт гаргасан тул хүсэлтийн дагуу 21 дүгээр зөрлөгийн баруун урд талд 122,5 га газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар Страто ХХК-д 11 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшил газраа нэгтгэж буй Страто ХХК-ийн захирал (А.Баттүшиг)-т газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг үүрэг болгосугай.

3. Хуулийн дагуу эзэмшил газраа нэгтгэж буй Страто ХХК-ийн захирал А.Баттүшигтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны А/95, 2019 оны А/128 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

421210694